

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС ХХК НАРЫН ХООРОНД БАЙГУУЛСАН “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ”-НИЙ 2024 ОНЫ 2024/109 ДУГААР ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 05 дугаар сарын 02

Баянхонгор аймаг

№	Гэрээний тусгай нөхцөл	Хэрэгжилт	Үнэлгээ /Хувиар/
1	2	3	4
1	3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;	Төслийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулаагүй байна.	100%
2	3.1.2.Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр Хөдөлмөр халамж үйлчилгээний газраар дамжуулан эсвэл олон нийтийн хэрэгсэл болон цахимаар нийтэд зарлах	Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжин Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай холбогдож ажилд орох хүсэлтэй иргэдийн мэдээлэл авч ажилладаг бөгөөд орон нутгийн цахим хаягуудаар болон Unegui.mn , Zanqia.mn сайтуудаар ажлын байрны нээлттэй зарыг байршуулж ажилласан.	70%
3	3.1.3.Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах	Уурхайн Хүдэр баяжуулах үйлдвэр,-Технологийн хэсэг, Засварын хэсэг, Цахилгааны хэсэг, Менежментийн алба, Санхүү, бүртгэлийн алба, ХАБЭАБО алба, Уулын хэсэг, Кемп аж ахуйн хэсэг, Лабораторид нийт орон нутгийн 64 ажилтанг ажлын байран дээр сурган ажиллуулж байна. Мөн 2025 оны 02 сарын 19-ны өдөр Улаанбаатар хотын “MKL”ХХК-ийн дэргэдэх сургалт, зөвлөх үйлчилгээний төвтэй хамтран “Химийн хорт бодистой харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагаа” сэдэвт цахим сургалтанд байгууллагын 8 ажилчдыг хамруулан сертификат, үнэмлэх олгосон байна.	100%
4	3.1.4. Ажиллах хүчнийхээ 50-иас доошгүй хувийг орон нутгаас ажиллуулах, Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэдээллийн санд бүртгэлтэй иргэдээс ажилд авах	2023 оны 12 сарын 26-ны өдрийн тус компанийн Хувьцаа эзэмшигчийн хурлаар 150 ажлын байрны бүтэц орон тоо батлагдсан. Одоогоор 121 ажилтантай ажиллаж байгаа бөгөөд үүний 53.35 доошгүй хувь буюу 64 орон нутгийн ажил горилогчийг ажлын байраар хангаж сургаж ажиллуулсан байна.	100%

5	3.1.5. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх	Төслийн үйл ажиллагааны талаар сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч болон байгаль хамгаалагчид сар бүрийн ажлын мэдээ болон БОМТ-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнаж ажиллаж байна. Мөн сар бүрийн ус ашиглалтын мэдээг орон нутгийн байгаль хамгаалагч, БОХУБайцаагчаар хянуулж, баталгаажуулж ажиллаж байна	100%
6	3.1.6. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, зохих байгууллагаар хянуулсан уулын ажлын төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэргийг биелүүлж ажиллах;	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон уулын ажлын төлөвлөгөөг дээд байгууллагаар батлуулан, тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсэн үнэлгээний нэмэлт тодотголыг "Ашид ананда" ХХК боловсруулан батлуулсан байна.	100%
7	3.1.7. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг бүрэн хийж гүйцэтгэх;	Баянхонгор аймгийн БОАЖГ-ын саналаар Бөмбөгөр сумын 1-р багийн нутаг болох Хөх булгийн хөндий №1 2.14га, Хөх булгийн хөндий №2 1.73га, Муу худаг №1 4.65га газарт техникийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. Нийт 8.52га талбайд экскаватор, ковшоор түрэлт хийн дүүргэлт хийж, тэгшилж, техникийн нөхөн сэргээлтийн стандартын дагуу хийж гүйцэтгэсэн.	100%
8	3.1.8. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;	Төслийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд жил бүр гамшгийн үед шаардлагатай техник, тоног төхөөрөмж, ажиллах хүч, бусад материалаар туслхаар төлөвлөсөн байдаг.	100%
9	3.1.9. Эрх бүхий байгууллага албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах;	Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс Улсын байцаагчийн албан шаардлага, Баянхонгор аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газар Улсын байцаагчийн албан шаардлага, Бөөнцагаан-Орог нуурын сав захиргаа Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ирүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж, хариу тайланг хугацаанд нь албан тоотын хамт хүргүүлж ажилласан байна.	100%
10	3.1.10. Уул уурхайн ил тод байдлыг бий болгож, олборлосон баялаг, татвар төлбөрөө тайлагнаж байх;	Жил бүр АМГТГ-т Ашиглалтын үйл ажиллагааны тайлан, Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба, Татварын ерөнхий газар, Баянхонгор аймгийн Татвар, Бөмбөгөр сум Татвар зэрэг байгууллагуудад холбогдох тайлангуудыг илгээж ажилладаг.	100%
11	3.1.11. Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуулийн 35.3-р зүйлд заасан бичиг баримтын бүрдлийг бүрэн хангасан тохиолдолд ажлаа эхэлж байх;	Уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах бичиг баримтын бүрдэлийг бүрдүүлж ажиллаж байна.	100%
12	3.1.12. Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд аймаг, сумын өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачилга гаргах;	Бөмбөгөр сумын хогийн нэгдсэн цэгийг Засаг даргын хүсэлтээр ландшафт хийж өгч ойр орчмыг түрж янзалж өгсөн. Уурхайн нийгмийн хариуцлагын хүрээнд Улаан сайр 1-р багийн малчин иргэн Л.Наранцэцэгийн ойролцоох	100%

		худаг үерийн усаар хайрга, дайрганд дарагдсан байсныг уурхайн техник хэрэгслээр түрж худгийг ажиллагаанд оруулж өгсөн. Мөн Улаансайр 1-р багийн малчин иргэдийн хүсэлт, өргөдлийг харгалзан боломж бололцоогоор дэмжиж шийдэж ажилладаг. Энэ онд 16 өргөдлийг шийдвэрлэж өгсөн байна.	
13	3.1.13. Орон нутагт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнтэй ижил төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаднаас буюу бусад зах зээлээс авахгүй байх, орон нутгийн тухайлсан ААН-тэй гэрээ байгуулах;	Уурхайн ажилчдын хүнс, бараа Уурхайн ажилчдын хүнс татан авалтыг Баянхонгор аймгийн төвд байрлах Богд-Эрдэнэ хүнсний бөөний төв болон Миний сүлжээ дэлгүүр, Их богд махны зах, Мах маркетын салбар дэлгүүрээс, Бөмбөгөр суманд байрлах Петровис шатахуун түгээх станцаас уурхайн тээврийн хэрэгслийн шатахууныг тус тус худалдан авч ажиллаж байна. Сантехник, засвар үйлчилгээний сэлбэг хэрэгсэлийг орон нутгийн Цэлмэг өглөө дэлгүүрээс худалдан авалт хийдэг.	100%
14	3.1.13.1.Мах, сүү, хүнсний ногоог 100% тухайн орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан худалдан авах;	Уурхайн ажилчдын хүнс татан авалтыг Баянхонгор аймгийн төвд байрлах Бүрд-Ээж"ХХК- тай гэрээ байгуулан мах, сүү, ногоо татан авалт хийдэг. Өндөг мах махан бүтээгдэхүүн "Танан хишиг" ХХК гэрээ байгуулан худалдан аван хийж байна. Богд-Эрдэнэ хүнсний бөөний төв; Миний сүлжээ дэлгүүр, Их богд махны зах, Мах маркетын салбар дэлгүүрүүдээс мөн худалдан авалт хийж байна.	100%
15	3.1.14.2.Ажлын хувцас, дээжний уутийг тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан худалдан авах;	Ажлын хувцас болон дээжний уутыг Улаанбаатар хотоос худалдан авалт хийж ажиллаж байна.	100%
16	3.1.13.3.Харуул хамгаалалтыг сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжид давуу эрх олгох;	Манай компани нь "Өндөр сонор секьюрити" ХХК-тай харуул хамгаалалтын компанитай хамтран ажилладаг бөгөөд тус компани нь харуул хамгаалалтын ажилтнаа орон нутгаас сонгон шалгаруулан авч ажиллуулдаг болно.	100%
17	3.1.13.4.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 7, 28 дугаар заалтуудын дагуу ажлын байрны эрүүл ахуйн шаардлага стандартыг хангах зорилгоор халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах, хүний эрүүл мэндэд хор хөнөөлтэй хортон шавж, мэргч устгал, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийхдээ тусгай зөвшөөрөл бүхий өмчийн оролцоотой орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;	Баянхонгор аймгийн Номгон-Ариусал ХХК-тай ариутгал халдваргүйжүүлэлтийн гэрээтэй ажилладаг. Мөн уурхайн эмч, эрүүл ахуйч сар бүрийн хуваарийн дагуу урьдчилан сэргийлж үйлчилгээний ажилчидаар гал тогоо, нийтийн 00, угаалгын өрөөг ариутгал хийлгэж ажилладаг.	100%
18	3.1.14.Аж ахуйн үйл ажиллагааны ашгаас авах татвараас бусад татвар шимтгэлүүдийг орон нутгийн төсөвт төлдөг байх;	Гэрээний хугацаанд Ус ашигласны төлбөр 10,724,767 төгрөг, Хог хаягдлын төлбөр 2400,000 төгрөг, Агаар бохирдуулсны төлбөр 235,100 төгрөг, Үл хөдлөх хөрөнгө 4,212,260.72 төгрөг, Техникийн хяналт 1,000,000 төгрөг, Газар ашигласны төлбөр 10749960 төгрөгийг төвлөрүүлээд байна.	100%

19	3.1.15. Ус ашигласны төлбөрийг тоолуураар хуулийн хугацаанд нь төлнө. Хэрвээ усны тоолуур суурилуулаагүй бол Эрх бүхий байгууллагаас баталсан дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай ноогдуулалтын гэрээ хийж, төлбөрийг орон нутагт тушаана. Ус ашигласны төлбөрийг дүгнэлтээр төлөх тохиолдолд 50-иас доошгүй хувийг ажил эхлэхэд Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна;	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын даргын 2024 оны 06 сарын 18-ны өдрийн Е-2405-000009 дугаартай Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаатай 2024 оны 06 сарын 26 өдрийн А/27 дугаартай "Ус ашиглах зөвшөөрөл", 2024 оны 07 сарын 01 өдрийн 04 дугаартай "Ус ашиглах гэрээ"-г байгуулсан. Усны тоолуурын баталгаажуулалтаар одоогоор нийт 9,114,404.544 төгрөг төлсөн.	100%
20	3.1.16. Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.18, 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх;	Стандарт, хэмжилзүйн газрын 066303 гэрчилгээтэй, №202001989 дугаар тоолуурыг 1-р худаг, 066298 гэрчилгээтэй, №01155 дугаар тоолуурыг 2-р худагт суурилуулан ашиглаж байна.	100%
21	3.1.17. Гэрээний хэрэгжилтийн техник хяналтын зардал болох 1,000,000 (нэг сая) төгрөгийг Баянхонгор аймгийн төрийн сангийн "БХ-Хяналт техник – 100030051370" тоот дансанд гэрээ байгуулсны дараа байршуулна.	Баянхонгор аймгийн төрийн сангийн "БХ-Хяналт техник – 100030051370" тоот дансанд гэрээ байгуулсны дараа байршуулсан болно.	100%
Гэрээний хэрэгжилтийн дундаж хувь:			94,2%

ХЯНАСАН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА:

Д.МӨНХСАЙХАН

ДҮГНЭСЭН

БҮС, ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ФРУУЛАЛТ, БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХӨЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭНХБАЯР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

"ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС ХХК-ИЙ
УУРХАЙН ДАРГА

Э.БАТТУЛГА

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДОНЧИМЭГ

